ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны ... дугаар Дугаар ... Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ /У.Санрайжав/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ Э.САМДАН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал			Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	Эзлэхүүнээр		төг/м^3	1,800.0
		Хэмжүүрээр	хувьсах	төг/ГЖ	27,641.5
			тогтмол	төг/м^3	1,063.3
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	Эзлэхүүнээр		төг/м^3	1,600.0
		Хэмжүүрээр	хувьсах	төг/ГЖ	24,570.2
			тогтмол	төг/м^3	945.2
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан			төг/ м^3	4,000.0
				төг/хүн	5,000.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0” –ын өрөөний халаалт хамаарна)			төг/м^2	800.0
5	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан			төг/м^3	4,000.0
6	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м^2 хүртэл талбайтай		төг/сар	3,000.0
		41-81 м^2 талбайтай		төг/сар	5,000.0
		81 м^2-с дээш талбайтай		төг/сар	10,000.0